



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын сургуульд дасан зохицох болон бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар баталсан чиглэлийг 2026–2027 оны хичээлийн жилд хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т тус тус үүрэг болгосугай.

3.Нэгдүгээр ангид элсэн суралцагчдыг сургуульд дасан зохицоход дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтран ажиллах цагийг хичээлийн жилийн нэгдүгээр улирлын туршид долоо хоногт 3 цагаар тооцон нэгдүгээр ангийн багш нарт цалин хөлсийг бүрэн олгохыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010778

Боловсролын сайдын
2026 оны 08 дугаар сарын 31 ны өдрийн
11/277 дугаар тушаалын хавсралт

НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАЛЦАГЧИЙН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ БОЛОН “БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Үндэслэл, хэрэгцээ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д нийцүүлэн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг Боловсролын сайдын 2025 оны А/404 дүгээр тушаалаар, Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг Боловсролын сайдын 2026 оны А/46 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталсан. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт хүүхэд төвтэй, идэвхтэй болон тоглоомд суурилсан суралцахуй, нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжил, бие даах байдал, хамтран ажиллах, сонголт хийх, эхэлснээ дуусгах, алдааны дараа дахин оролдох чадварыг дэмжихээр тусгасан. Уг хөтөлбөр нь сургалтын агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн нэгдмэл байдлаар төлөвлөхийг шаарддаг. Бага боловсролын сургалтын хөтөлбөр нь суралцагчийн суурь болон ерөнхий чадамжийг судлагдахуун бүрийн суралцахуйн үр дүнгээр хөгжүүлэх, мэдлэг, чадварыг бодит нөхцөлд хэрэглэх, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, хамтран суралцах, бүтээлчээр илэрхийлэх арга зүйг баримталсан.

Хүүхэд нэгдүгээр ангид элсэх нь сургуулийн өмнөх боловсрол, гэр бүлийн танил орчноос шинэ орчин, хүмүүс, харилцаа, өдөр тутмын дэг болон суралцах үйл ажиллагаанд шилжих чухал үе юм. Энэ үе нь хүүхэд зөвхөн нэг байгууллагаас нөгөөд шилжих үйл явдал биш бөгөөд орчин, хүмүүс, харилцаа, өдөр тутмын хэмнэл, үүрэг, суралцах арга хэлбэр зэрэг олон зүйл нэгэн зэрэг өөрчлөгддөг шилжилтийн үе юм. Дасан зохицох явц нь хүүхдийн өмнөх туршлага, хөгжлийн онцлог, гэр бүлийн нөхцөл, багштай тогтоох харилцаа, ангийн орчин болон сургуулийн зохион байгуулалтын харилцан үйлчлэлээс хамаарна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын “*Starting Strong V*” тайланд чанартай шилжилт нь урьдчилан төлөвлөсөн, хүүхэд төвтэй, мэргэжлийн ажилтнуудын хамтын ажиллагаанд тулгуурласан, сургалтын хөтөлбөрийн залгамж холбоог хангасан байх шаардлагатайг онцолсон. Ийм шилжилт нь сургуулийн өмнөх боловсролын үр нөлөөг бага боловсролын түвшинд үргэлжлүүлэх нөхцөл болдог.

Сургуульд шилжих үйл явцыг хүүхдийн “сургуульд бэлэн байдал”-аар дангаар тайлбарлахгүй. Хүүхэд, гэр бүл, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, багш, үе тэнгийнхэн болон орчны харилцан үйлчлэлд явагдах тасралтгүй үйл явц гэж үзнэ. Шилжилтийн экологийн загвар нь дасан зохицоход тулгарсан бэрхшээлийг зөвхөн хүүхдийн онцлогоор бус, орчин, харилцаа, хүлээлт, арга зүй, дэмжлэгийн тохирцоор хамтатган авч үзэхийг зөвлөдөг (Rimm-Kaufman & Pianta, 2000; OECD, 2017).

Чанартай шилжилт нь урьдчилан төлөвлөсөн, хүүхэд төвтэй, гэр бүл болон мэргэжлийн ажилтны хамтын ажиллагаанд тулгуурласан, сургалтын хөтөлбөрийн залгамж холбоог хангасан байна. Сургууль хүүхдийн ялгаатай туршлага, хэрэгцээг хүлээн авахад бэлтгэгдсэн байх нь хүүхдийг сургуульд бэлтгэхтэй адил ач холбогдолтой (OECD, 2017).

Япон, Шинэ Зеланд, Австралийн Викториа мужийн шилжилтийн бодлогод сургуулийн өмнөх боловсролоос сургуульд шилжих залгамж холбоо, хүүхдийн өмнөх туршлага, сонирхол, дэмжлэгийн хэрэгцээний талаарх мэдээллийг гэр бүл, боловсролын

байгууллагууд хамтран ашиглахыг чухалчилдаг. Сингапурын бага ангийн идэвхтэй суралцах хөтөлбөр нь урлаг, хөдөлгөөн, тоглоом, гадаах орчны үйл ажиллагааг сургалтын цагаар бүх суралцагчид тэгш хүртээмжтэй хэрэгжүүлдэг байна.

Сургуульд шинээр элссэн суралцагчид анхаарлаа төвлөрүүлэх, заавар дагах, ээлжээ хүлээх, мэдрэмж, хэрэгцээгээ илэрхийлэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах, бусадтай хамтран ажиллах шаардлага нэмэгддэг. Иймээс эхний үед тогтвортой дэг, ойлгомжтой дохио, эерэг харилцаа, тоглоом, хөдөлгөөн, сонголт, давтан оролдох боломжийг бүрдүүлэх нь суралцах үйл ажиллагаанд оролцох суурь болдог (Blair & Raver, 2015).

Зургаан настай суралцагч бодит зүйлтэй ажиллах, тоглох, хөдөлгөөн хийх, ажиглах, асуулт асуух, турших, бүтээх, хийснээ хуваалцах үйлээр мэдлэг, чадвараа утга учиртай хэрэглэнэ. Чиглүүлэгтэй тоглоом нь тодорхой зорилго, суралцагчийн сонголт, багшийн зохистой дэмжлэгийг хослуулсан үед зарим суралцахуйн үр дүнд эерэг нөлөөтэй байж болохыг судалгаанд тэмдэглэсэн (Skene нар, 2022).

НҮБ-ын Хүүхдийн сангийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үзэл баримтлалд “бэлтгэгдсэн хүүхэд”, “бэлтгэгдсэн гэр бүл”, “хүүхдийг хүлээн авахад бэлтгэгдсэн сургууль” гэсэн харилцан хамааралтай гурван хүрээг авч үздэг. Энэ нь хүүхдэд тавих шаардлагыг дангаар нэмэгдүүлэхээс илүү гэр бүл, сургууль болон дэмжих үйлчилгээний хамтын хариуцлагыг тодорхойлох үндэс болж байна.

Монгол Улсад хэрэгжүүлсэн I ангийн “Бэлтгэл” хөтөлбөрийн туршлага, сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаа нь сургуулийн орчин, багшийн бэлтгэл, гэр бүлийн дэмжлэг, хүүхдийн өмнөх туршлага болон сургалтын арга зүйг цогцоор авч үзэх шаардлагатайг харуулжээ. Малчин болон алслагдсан өрхийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг дэмжсэн туршлага нь байршил, амьдралын хэв маяг, хэл, соёлын онцлогт нийцсэн уян хатан зохион байгуулалтын ач холбогдлыг онцолсон.

1.2. Зорилго, зориулалт:

Дээрх хэрэгцээ, үндэслэлд тулгуурлан энэхүү чиглэл нь хүүхдийн өмнөх туршлагад суурилсан залгамж холбоо, сургууль, гэр бүлийн хамтын хариуцлага, бодит үйл ба тоглоомд суурилсан суралцахуй, ялгаатай хэрэгцээнд тохирсон дэмжлэг, өдөр тутмын ажиглалт болон эргэх холбоог хэрэгжилтийн үндсэн чиглэл болгон дараах үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах чиглэл, зарчим, шаардлагыг тогтооно. Үүнд:

а. Нэгдүгээр ангид шинээр элсэн орж буй суралцагчийг хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт сургуулийн орчин, харилцаа, өдөр тутмын болон суралцах үйл ажиллагаанд аажмаар дасан зохицоход дэмжлэг үзүүлэх;

б. Нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан “Бүтээлч үйл ажиллагаа”-г сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, суурь болон ерөнхий чадамжтай уялдуулан хэрэгжүүлэх зохион байгуулах.

Сургуульд дасан зохицох үйл ажиллагаа нь бие даасан судлагдахуун, нэмэлт хичээл биш бөгөөд нэгдүгээр ангид шинээр элсэн суралцаж буй суралцагчийг сургуулийн орчин, харилцаа, өдөр тутмын дэг, бие даах болон суралцах үйл ажиллагаанд аажмаар оролцоход дэмжлэг үзүүлэх, сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоог хангахад чиглэнэ.

“Бүтээлч үйл ажиллагаа” нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг бодит нөхцөлд хэрэглэх, судлах, турших, бүтээх, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах үйл ажиллагаагаар дамжуулан суурь болон ерөнхий чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Энэхүү чиглэл нь сургуульд дасан зохицох үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрөөс тусгаарлахгүй байх, “Бүтээлч үйл ажиллагаа”-г судлагдахуун хоорондын уялдаа, бодит хэрэглээнд тулгуурлан зохион байгуулах үндэслэл болно.

1.3. Хамрах хүрээ:

Чиглэлийг өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, сургалтын менежер, нэгдүгээр ангийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, хоол зүйч болон бусад холбогдох ажилтан үйл ажиллагааны чиг үүрэгтээ нийцүүлэн хэрэгжүүлнэ. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн сургуульд шилжих, дасан зохицох болон суралцах үйл ажиллагааг дэмжих хамтрагч байна.

1.4. Баримтлах зарчим

Нэгдүгээр ангийн суралцагчийн дасан зохицох болон бүтээлч үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, ажиглах, үнэлэхдээ дараах нийтлэг зарчмыг баримтална.

1. Хүүхдийн эрх, эрхэм чанар, аюулгүй байдлыг хангах:

Суралцагчийн үзэл бодол, мэдрэмж, сонголт, хэл, соёл, ялгаатай байдлыг хүндэтгэж, бие махбодын болон сэтгэл зүйн хувьд аюулгүй, хамгаалагдсан орчин бүрдүүлнэ. Суралцагчийг айлгах, ичээх, харьцуулах, шошголох, ялгаварлан гадуурхах, албадах үйлдэл гаргахгүй.

2. Хүүхэд төвтэй, идэвхтэй, бүтээлч оролцоог дэмжих:

Суралцагчийг бэлэн мэдээлэл хүлээн авагч бус, ажиглах, асуух, сонгох, тоглох, судлах, турших, бүтээх, асуудал шийдвэрлэх, хийснээ илэрхийлэх үйл ажиллагааны идэвхтэй оролцогч гэж үзнэ. Багш суралцагчийн санаачилга, сонирхлыг зорилготой чиглүүлж, оролцох олон хувилбар бүрдүүлнэ.

3. Нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн үе шаттай, уян хатан зохион байгуулах:

Үйл ажиллагааг суралцагчийн анхаарал төвлөрөх хугацаа, хөдөлгөөний хэрэгцээ, хэл яриа, бие даах байдал, өмнөх туршлага, суралцах хэмнэлд нийцүүлнэ. Танилаас шинэ рүү, бодит зүйлээс дүрслэл рүү, богино үйлээс үргэлжилсэн алхамтай үйл рүү аажмаар шилжүүлж, шаардлагатай үйл ажиллагааг давтан хэрэгжүүлнэ.

4. Тэгш хамруулах, ялгаатай хэрэгцээнд тохируулга хийх:

Суралцагч бүрийг үйл ажиллагаанд оролцох боломжтой байхаар арга зүй, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн, заавар болон хариу илэрхийлэх хэлбэрт тохируулга хийнэ. Тохируулгыг суралцагчийг тусгаарлах бус, оролцоонд тулгарч буй саадыг бууруулахад чиглүүлнэ.

5. Бодит амьдралтай уялдсан, интеграцчилсан суралцахуйг хэрэгжүүлэх:

Мэдлэг, чадварыг тусгаарлан давтуулахгүй, сургуулийн өдөр тутмын амьдрал, орон нутгийн орчин, байгаль, соёл, ахуйтай холбоотой бодит үйл ажиллагаагаар хэрэглүүлнэ. Судлагдахуунуудын суралцахуйн үр дүн, суурь болон ерөнхий чадамжийг тухайн үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн уялдуулна.

6. Сургууль, гэр бүл, мэргэжлийн ажилтны хамтын ажиллагааг хангах

Сургуулийн удирдлага, багш, бусад ажилтан, эцэг эх, асран: хамгаалагч болон шаардлагатай мэргэжлийн ажилтан үүрэг, мэдээлэл, дэмжлэгээ уялдуулан ажиллана. Хүүхдийн талаарх мэдээллийг зөвхөн түүнийг дэмжих зорилгоор, холбогдох зөвшөөрөл, нууцлалын шаардлагыг ханган ашиглана.

7. Ажиглалт, нотолгоо, эргэх холбоонд тулгуурлан дэмжих:

Суралцагчийн оролцоо, ахиц, хэрэгцээг өдөр тутмын бодит үйл ажиллагаагаар дамжуулан ажиглаж, ялгаатай нөхцөл, хугацаанд цуглуулсан баримт, нотолгоонд үндэслэн дараагийн дэмжлэгийг төлөвлөнө. Ажиглалт, үнэлгээг суралцагчийг эрэмбэлэх, бусадтай харьцуулах, “дассан–дасаагүй”, “чадсан–чадаагүй” гэж ангилахад ашиглахгүй.

1.5. Арга зүй

Нийгэм-сэтгэл хөдлөл, өөрийгөө зохицуулах чадварыг дэмжих нь

Сургуульд шинээр элссэн хүүхэд анхаарлаа төвлөрүүлэх, зааврыг дагах, ээлжээ хүлээх, мэдрэмж болон хэрэгцээгээ илэрхийлэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах, бусадтай хамтран ажиллах зэрэг үйлийг шинэ нөхцөлд хэрэгжүүлэх шаардлагатай болдог.

Өөрийгөө зохицуулах чадвар нь суралцах үйл ажиллагаанд оролцох, анхаарал төвлөрүүлэх, зорилготойгоор үйлдлээ үргэлжлүүлэх боломжтой холбоотойг сургуульд бэлтгэгдсэн байдал, өөрийгөө зохицуулах хөгжлийн талаарх судалгаанд тэмдэглэсэн. Иймээс дасан зохицох эхний үед академик агуулгыг богино хугацаанд нэмэгдүүлэхээс

илүүтэй тогтвортой дэг, ойлгомжтой дохио, эерэг харилцаа, хөдөлгөөн, тоглоом, сонголт, даван оролдох боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Сургуулийн өмнөх боловсролын 2025 оны сургалтын хөтөлбөрт өөрийн мэдрэмж, хэрэгцээг илэрхийлэх, тайвшрах арга хэрэглэх, бусадтай харилцах, өдөр тутмын үйл ажиллагаанд дүрэм баримтлан оролцох, сонголт хийх, эхэлснээ дуусгах үр дүнг тусгасан. Иймээс I ангийн эхний үеийн арга зүй нь хүүхдийн өмнөх туршлагыг шинэ орчин, шинэ шаардлагатай аажмаар холбоход чиглэнэ.

Тоглоом, судлах, турших, бүтээх үйлээр суралцах нь

Зургаан настай суралцагчид бодит зүйлтэй ажиллах, хөдөлгөөн хийх, тоглох, ажиглах, асуулт асуух, сонголт хийх, турших, алдаагаа засах, хийснээ бусадтай хуваалцах үйлээр мэдлэг, чадвараа хэрэглэдэг. Иймээс тоглоом болон суралцах үйл ажиллагааг эсрэгцүүлэхгүй, тодорхой зорилго, багшийн тохирсон чиглүүлэг, суралцагчийн сонголт, санаачилгыг хослуулна.

Чиглүүлэгтэй тоглоомын талаарх системчилсэн тойм, мета-шинжилгээнд 1–8 насны хүүхдийг хамарсан 39 судалгааг шинжилж, чиглүүлэгтэй тоглоом нь эрт үеийн математик, дүрс, орон зайн үгийн сан зэрэг зарим үр дүнд эерэг нөлөөтэй байж болохыг тогтоосон боловч бүх чиглэлд ижил үр нөлөө нотлогдоогүйг тэмдэглэсэн. Иймд энэхүү чиглэлд тоглоомыг дангаар нь үр дүн гэж үзэхгүй, зорилго, ажиглалт, асуулт, туршилт, бүтээл болон эргэцүүлэлтэй уялдуулна.

Бүтээлчээр сэтгэхийг шинэ бөгөөд олон янзын санаа гаргах, санаагаа үнэлэх, сайжруулах үйл явц гэж олон улсын үнэлгээний хүрээнд тодорхойлсон. Энэхүү тодорхойлолтыг I ангийн суралцагчийг үнэлэх стандарт болгон хэрэглэхгүй бөгөөд “Бүтээлч үйл ажиллагаа”-ны хүрээнд санаа гаргах, хувилбар турших, хийснээ өөрчлөх, сайжруулах арга зүйн баримжаа болгон ашиглана.

ХОЁР. НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАЛЦАГЧИЙН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ БОЛОН “БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ЗҮЙ

1.6. Чиглэлийн бүтэц

Энэхүү чиглэл нь доор дурдсан бүтэцтэй байна. Үүнд:

Нэгдүгээр хэсэг. “Сургуульд дасан зохицох үйл ажиллагаа”

Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхэд багшид зориулсан “Нэгдүгээр ангийн суралцагчийн сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж”, сурагчид зориулсан “Би сурагч боллоо” дасгалын дэвтрийг ашиглана.

Хоёрдугаар хэсэг. ‘Бүтээлч үйл ажиллагаа’

Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхэд багшид зориулсан “Бүтээлч үйл ажиллагаа”-г хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж, жишиг төлөвлөлтийг ашиглана.

“Нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварт суралцах үйл ажиллагаа”, “Бүтээлч үйл ажиллагаа” болон сургуульд дасан зохицох эхний дөрвөн долоо хоногийн үйл ажиллагаа нь зорилго, хугацаа, зохион байгуулалтын хувьд ялгаатай боловч суралцагчийн сайн сайхан байдал, харилцаа, оролцоо, суралцахуйг дэмжих нийтлэг чиглэлээр харилцан уялдана.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Зорилго, хамрах хүрээ

Нэгдүгээр ангид шинээр элсэн суралцаж буй суралцагчийг сургуулийн орчин, харилцаа, өдөр тутмын дэг, бие даах болон суралцах үйл ажиллагаанд аажмаар, аюулгүй, идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлж, бага боловсролын суралцахуйд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хэсгийн зорилго оршино.

Үйл ажиллагаа нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэх, өмнөх туршлага, хэл, соёл, байршил, хөгжлийн онцлог, ялгаатай болон бусад дэмжлэгийн хэрэгцээнээс үл хамааран нэг дүгээр ангид шинээр элссэн бүх суралцагчид хамаарна.

Хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт дасан зохицох үйл ажиллагааг бүх суралцагчид нийтлэг, төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ. Суралцагчийн оролцоо, ахиц, хэрэгцээнд үндэслэн шаардлагатай дэмжлэгийг I улирал болон цаашдын сургалтын явцад үргэлжлүүлнэ.

1.2. Хүрэх үр дүн

Чиглэлийг хэрэгжүүлэх явцад суралцагч дараах үйлийг бие даан эсхүл тохирсон дэмжлэгтэйгээр гүйцэтгэж чаддаг болсон байна. Суралцагчид ажиглагдаж буй ахиц, үр дүнг шаардлагатай дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох, дараагийн үйл ажиллагааг төлөвлөхөд суурь мэдээлэл болгон ашиглана.

Чиглэл	Хүлээгдэж буй үр дүн/Ажиглагдах үр дүн
Орчноо таньж, шаардлагатай үед тусламж хүсэх	Анги, ариун цэврийн өрөө, цайны газар, орох-гарах хэсгийг танина; зураг, тэмдэглэгээг ашиглан хэрэгтэй газраа бие даан болон бусдын дэмжлэгтэйгээр олно; төөрсөн, өвдсөн, айсан гэх мэт тусламж шаардлагатай үед хэнд, хэрхэн хандахаа мэдэж, үг, зураг, дохио, хөдөлгөөн зэрэг өөрт тохирох хэлбэрээр тусламж хүснэ.

Бусадтай харилцаж, хамтран оролцох	Өөрийгөө танилцуулах, бусдыг сонсох, ээлжээ хүлээх, талархах, уучлал хүсэх зэрэг харилцааны энгийн үйлүүдийг бие даан хийнэ, Хос, жижиг бүлгийн үйл ажиллагаанд тохирсон үүрэгтэй оролцоно.
Дэг мөрдөх, зааврын дагуу бие даан ажиллах	Зурагт хуваарь, багшийн дохиог дагах; цүнх, хувцас, хэрэглэгдэхүүнээ байранд нь тавих; гараа угаах; хооллох; ариун цэврийн өрөөг ашиглах; хэрэглэсэн зүйлээ хураах зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд дэг, зааврын дагуу оролцоно.
Суралцах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох	Нэгээс хоёр алхамтай зааврын дагуу үйл ажиллагааг эхлүүлж, үргэлжлүүлж, дуусгана (зурагт болон бодит дэмжлэгтэйгээр). Хэрэглэгдэхүүнээ сонгож ашиглан, хийснээ үг, зураг, бүтээл, дохио, хөдөлгөөнөөр илэрхийлнэ.
Мэдрэмж, хэрэгцээгээ илэрхийлж, өөрийгөө зохицуулах	Өөрийн мэдрэмж, сонирхол, дуртай, дургүй зүйл, тусламж хэрэгтэй байгааг өөрт тохирох хэлбэрээр илэрхийлэнэ. Тайвшрах, завсарлага авах болон насанд хүрэгчээс дэмжлэг хүсэх энгийн аргыг хэрэглэнэ.
Шинэ туршиж, үйлийг дахин оролдох	Танил бус үйл ажиллагааг дэмжлэгтэйгээр турших; шууд хийж чадаагүй үед дахин оролдох; өөр арга, материал, хувилбар сонгох; хийснээ эргэн харах дадалд суралцана

1.3. Агуулга

Дасан зохицох үйл ажиллагааг суралцагч шинэ орчинд тайван, аюулгүй байхаас эхлэн бусадтай харилцах, өдөр тутмын дэгийг дагах, бие даах, улмаар суралцах үйл ажиллагаанд итгэлтэй оролцох дарааллаар хэрэгжүүлнэ.

Долоо хоног	Сэдэв	Зорилго	Нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг дэмжих чиглэл
I	Манай сургууль	Сургууль, анги, багш болон өдөр тутам ашиглах хэрэглэгдэхүүн, орчинтой танилцах; тэмдэглэгээгээр хэрэгтэй газраа олох; сургуульд ирэх, тарах, завсарлах, хооллох, ариун цэврийн дэгийг дагах; шаардлагатай үед тусламж хүсэх.	Шинэ орчинд тайван, аюулгүй байж, итгэлтэй хүнээс тусламж хүсэхэд дэмжлэг үзүүлнэ.
II	Бид нэг ангийнхан	Өөрийгөө танилцуулах, ангийн хүүхдүүдээ таних; бусдыг сонсох; ээлжээ хүлээх; хос, жижиг бүлгээр оролцох; туслах, талархах, уучлал хүсэх; ангийн дүрмийг дагаж мөрдөх.	Өөрийгөө ангийн хамт олны нэг хэсэг гэж мэдэрч, бусадтай эерэг харилцаа тогтооход дэмжлэг үзүүлнэ.
III	Би сургуулийн сурагч	Зурагт хуваарь, үйл ажиллагааны дарааллыг дагах; нэгээс хоёр алхамт зааврын дагуу үйлээ эхлүүлж дуусгах; хэрэглэгдэхүүнээ сонгон авч, зөв ашиглаж, хураах; өдөр тутмын энгийн үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх.	Өдөр тутмын үүрэг, дэгийг ойлгож, бие даан оролцох итгэлийг дэмжинэ.

IV	Би суралцаж чадна	Сонголт хийх; суралцах үйл ажиллагаанд бие даан эсхүл тохирсон дэмжлэгтэйгээр оролцох; хийснээ эргэн харах, бусдад танилцуулах; шинэ зүйл турших; алдаа гарсан үед дахин оролдох.	Өөрийн ахицыг мэдрэх, шинэ үйлийг турших, суралцахад өөртөө итгэх итгэлийг дэмжинэ.
----	-------------------	---	---

Угтах, үдэх, зурагт хуваарь ашиглах, өөрийн эд зүйлээ цэгцлэх, ариун цэвэр сахих, хооллох, хөдөлгөөн хийх, хэрэглэгдэхүүнээ авч хураах, мэдрэмж, хэрэгцээгээ илэрхийлэх, өдрийн хийсэн зүйлээ эргэн санах үйлийг тогтмол хийж хэвших.

Дасан зохицох үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдуулна. Энэ уялдаа нь сонсох, ярих, асуух, тоолох, ангилах, харьцуулах, дараалуулах, сонголт хийх, хөдөлгөөнөөр илэрхийлэх, хамтран ажиллах чадварыг бодит нөхцөлд хэрэглэх боломжийг бүрдүүлэхийг зорино. Суралцахуйн үр дүнг хичээлийн хэлбэр, зохион байгуулалтаар шууд эзэмшүүлэхээс илүү дасан зохицох үйл ажиллагаанд шингээж хөгжүүлэх боломжийг эрэлхийлнэ.

1.4. Арга зүй, орчин, тохируулга

Сургуульд дасан зохицох үйл ажиллагааны арга зүй нь хүүхэд төвтэй, идэвхтэй, тоглоом, бодит үйлд суурилсан байна. Сургуулийн өмнөх боловсролд эзэмшсэн тоглох, ажиглах, сонгох, хөдөлгөөн хийх, турших, дүрслэх, хамтран ажиллах туршлагыг I ангийн суралцах үйл ажиллагаатай аажмаар холбоно.

Багш дараах арга зүйн чиглэлийг баримтална.

Чиглэл	Хэрэгжүүлэх шаардлага
Аажмаар шилжүүлэх	Танил орчноос шинэ орчин, бодит үйлээс зураг, тэмдэг, дүрслэл, богино үйлээс үргэлжилсэн үйл рүү аажмаар шилжүүлнэ.
Бодит үйлээс дүрслэл рүү шилжих	Эхлээд бодит орчинд очих, бодит хэрэглэгдэхүүн ашиглах, үйлдлийг биеэр гүйцэтгүүлэх, дараа нь зураг, тэмдэг, зурагт хуваарь, дэвтрийн дасгалтай холбоно.
Богино үйлээс үргэлжилсэн үйл рүү шилжих	Анхаарал төвлөрөх хугацааг харгалзан богино, тодорхой үйл ажиллагаанаас эхэлж, суралцагчийн оролцоо тогтворжихын хэрээр хугацаа болон алхмын тоог аажмаар нэмэгдүүлнэ.
Үзүүлэх, хамт хийх, бие даалгах	Багш үйлийг бодитоор үзүүлж, суралцагчтай хамт хийсний дараа дэмжлэгээ аажмаар багасган бие даах боломж олгоно.
Тоглоом, хөдөлгөөнд суурилсан арга зүйг ашиглах	Хөдөлгөөнт, хөлөгт болон бусад тоглоом, дүрд тоглох, дуу, хэмнэл, биеийн хөдөлгөөнийг үйл ажиллагааны зорилготой уялдуулна.
Хамтрах, сонголт хийх нөхцөлийг бүрдүүлэх	Нийт ангийн өмнө шууд ярихыг шаардахаас өмнө хос, жижиг бүлгээр оролцох боломж олгоно. Хэрэглэгдэхүүн, үүрэг, илэрхийлэх хэлбэрүүдээс суралцагч сонголт хийх нөхцөл бүрдүүлнэ.
Эерэг харилцааны орчин бүрдүүлэх	Зааврыг товч, нэг утгатай, нэгээс хоёр алхамтай өгч, зураг, бодит зүйл, дохиогоор дэмжинэ. Суралцагчийн оролдлого, ахиц, тусламж хүссэн болон дахин оролдсон үйлийг тодорхой үгээр дэмжинэ.

Аюулгүй, ойлгомжтой орчин бүрдүүлэх	Өдөр тутмын маршрут, өрөө, орох-гарах хэсгийг ойлгомжтой тэмдэглэж, зурагт хуваарь, тогтмол байрлал, хөдөлгөөн хийх, хамтран ажиллах болон тайвшрах боломжтой ангийн орчин бүрдүүлнэ.
Тохируулга хийх	Заавар, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн, бүлгийн хэмжээ, оролцох болон хариу илэрхийлэх хэлбэрийг суралцагчийн хэрэгцээнд нийцүүлнэ.

Нэгдүгээр ангид шинээр элсэн орсон суралцагчийн сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “Сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэх багшийн зөвлөмж”, “Би сурагч боллоо” суралцагчид зориулсан дасгалын дэвтрийг ашиглана. Эдгээр нь дөрвөн долоо хоногийн дасан зохицох үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөсөн жишиг төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, суралцагчийн дасгалын дэвтэр юм. Үүнийг гол зорилго, агуулгыг алдагдуулахгүйгээр орон нутгийн онцлог, орчин, нөхцөлдөө тохируулан хувиргаж, баяжуулж ашиглана.

Дасан зохицох үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүн нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, аюулгүй, ойлгомжтой, хүртээмжтэй байх ба хэт олон дүрс, бичвэрээр анхаарал сарниулахгүй байна. Танил орчны зураг, таних тэмдэг, зурагт хуваарь, дарааллын карт, бодит хэрэглэгдэхүүн, ном, тоглоом, дуу, хөгжим, хөдөлгөөн болон мэдрэмжээ илэрхийлэх хэрэглэгдэхүүнийг зорилгод нийцүүлэн ашиглана.

Эрүүл ахуй, хооллолт, аюулгүй байдлын үйлийг тайлбарлаад зогсохгүй бодит орчинд үлгэрлэн үзүүлэх, зурагт дараалал ашиглах, давтан дадлагажуулах арга зүйгээр хэрэгжүүлнэ.

1.5. Хэрэгжилт, зохион байгуулалт

Дасан зохицох дэмжлэгийг дараах харилцан уялдаатай үе шаттай зохион байгуулна.

Үе шат	Хугацаа	Гол үйл ажиллагаа
Шилжилтийн өмнөх бэлтгэл	Элсэлт баталгаажсанаас хичээл эхлэх хүртэл	Суралцагч, гэр бүлийг сургууль, анги, багш, ирэх-буцах зохион байгуулалттай танилцуулах; өмнөх туршлага, сонирхол, эрүүл мэнд, бие даах байдал, дэмжлэгийн хэрэгцээний талаар мэдээлэл солилцох; орчин, маршрут, тэмдэглэгээ, хүний нөөцийн бэлтгэлийг хангах.
Сургуульд дасан зохицох үе	Хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоног	Суралцагчийг сургуулийн орчин, харилцаа, өдөр тутмын дэг, бие даах болон суралцах үйл ажиллагаанд төлөвлөгөөтэй, аажмаар оролцуулах.
Тогтворжуулах үе	Тав дахь долоо хоногоос I улирлын төгсгөл хүртэл	Өдөр тутмын дэг, харилцаа, бие даах болон суралцах үйл ажиллагаанд оролцоог үргэлжлүүлэн ажиглаж, шаардлагатай дэмжлэг, тохируулгыг хэрэгжүүлэх.
Зорилтот дэмжлэгийг үргэлжлүүлэх үе	Хичээлийн жилийн турш шаардлагатай хугацаанд	Нэмэлт дэмжлэг шаардлагатай суралцагчид гэр бүл болон холбогдох ажилтантай хамтран тохирсон дэмжлэгийг үргэлжлүүлж, тодорхой хугацаанд эргэн хянах.

Чиглэлийн энэ хэсэгт хүүхэд сургуульд дасан зохицох хамгийн чухал үе буюу “Сургуульд дасан зохицох үе”-ийн зорилго, хамрах хүрээ, агуулга, хэрэглэгдэхүүн, хүрэх үр дүн, зохион байгуулалтын нийтлэг шаардлагыг тодорхойлно.

Боловсролын сайдын 2026 оны “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/257 дугаар тушаалаар баталсан Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн сургалтын төлөвлөгөө”-нд “Хичээлийн жилийн эхний 4 долоо хоногт суралцагчийн сургуульд дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Сургуульд дасан зохицох үйл ажиллагаа нь багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагаанд суурилан хэрэгжинэ. Иймд сургуульд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тогтворжуулахад бага боловсролын багш нь суралцагч нэг бүрийн эцэг, эх, асран хамгаалагчид зөвлөх, суралцагчийн сурах үйл явц, үр дүн, ахиц амжилтын талаар мэдээлэл солилцох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22.4-т заасан “Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх” хүрээнд хичээлийн жилийн эхний улиралд хэрэгжүүлнэ.

Энэхүү хамтын ажиллагааг сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан, тусгайлан зорилтот цагаар зохион байгуулах жишиг төлөвлөлтийг доорх хүснэгтээр харуулав.

№	Хичээлийн нэр	I улирал /хичээллэх долоо хоног/									Цаг
		1	2	3	4	5	6	7	8	9	
1	Монгол хэл	7	7	7	7	7	7	7	7	7	63
2	Математик	5	5	5	5	5	5	5	5	5	45
3	Байгаль шинжлэл										0
4	Нийгмийн ухаан										0
5	Хөгжим	2	2	2	2	2	2	2	2	2	18
6	Дүрслэх урлаг, технологи	2	2	2	2	2	2	2	2	2	18
7	Биеийн тамир	2	2	2	2	2	2	2	2	2	18
8	Эрүүл мэнд						1	1	1	1	4
9	Нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварт суралцах үйл ажиллагаа										
10	Бүтээлч үйл ажиллагаа	2	2	2	2	2	2	2	2	2	18
11	Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх, мэдээлэл хүргэх, хамтран ажиллах нэмэлт цаг	3	3	3	3	3	3	3	3	3	27
Нийт цаг		23	23	23	23	23	24	24	24	24	211
Бага ангийн багшийн цаг		19	19	19	19	19	20	20	20	20	175
Бусад багшийн цаг (хөгжим, биеийн тамир)		4	4	4	4	4	4	4	4	4	36

Энэхүү жишиг төлөвлөлт дэх “Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх, мэдээлэл хүргэх, хамтран ажиллах нэмэлт цаг”-ийг эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн сургуульд дасан зохицохтой холбоотой зөвлөгөө өгөх, мэдээлэл хүргэх, хамтран ажиллахад чиглүүлэх ба энэ цагийг багшийн хичээлийн цагт тооцно.

Сургуулийн түвшинд суралцагчийг хүлээн авах орчин, маршрут, тэмдэглэгээ, ирэх-буцах, хооллолт, ариун цэвэр, аюулгүй байдал, ажилтнуудын хамтын ажиллагаа болон эцэг эхэд мэдээлэл хүргэх зохион байгуулалтыг хичээл эхлэхээс өмнө бэлтгэнэ.

Нэгдүгээр ангийн ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 35 минут байна. Дасан зохицох нэг зорилгыг сургалтын цаг, завсарлага, хооллолт, ариун цэвэр, ирэх, тарах болон бусад зорилт, бодит үйлтэй уялдуулан нэг болон хэд хэдэн цаг, өдрийн турш, хэд хэдэн өдөр ч үргэлжлүүлж болно.

Нэгдүгээр анги даан авч буй багш зөвлөмжид тусгасан жишиг төлөвлөлтийг сургуулийн орчин, өдрийн хуваарь, суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулж ашиглана. Өдөр бүрийн зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хамтрах багш, ажилтан, шаардлагатай хэрэглэгдэхүүнийг өөрийн орчин нөхцөлд тохируулан урьдчилан төлөвлөнө.

“Би сурагч боллоо” сурагчийн дэвтрийг бодит үйл ажиллагааны дараа суралцагчийн хийсэн, ажигласан, туршсан үйлийг бататгах дагалдах хэрэглэгдэхүүн болгон ашиглана.

1.6. Дасан зохицох явцыг ажиглах, дэмжих

Ангийн багш нь суралцагчдын дасан зохицох явцыг өдөр тутам, тодорхой зорилго, төлөвлөлтийн дагуу тогтмол ажиглана. Энэхүү ажиглалт нь суралцагчийг шалгах, эрэмбэлэх, бусадтай харьцуулах, “бэлтгэлтэй–бэлтгэлгүй”, “дассан–дасаагүй” гэж ангилах бус суралцагчийн оролцоо, ахиц, дэмжлэгийн хэрэгцээг таньж, тохирох арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, тохируулгыг төлөвлөхөд чиглэнэ. Ажиглалт, түүний үр дүнд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, бусад ажилтнуудын тусламж, дэмжлэгийг авч хамтран ажиллана.

Ажиглалтыг хийхдээ багшийн зөвлөмжид санал болгосон зөвлөмж, арга, хэрэгслийг орчин, нөхцөл, хэрэгцээндээ тохируулан хувиргаж ашиглана.

Нэмэлт дэмжлэг шаардлагатай суралцагчийн хувьд ангийн багш сургалтын менежер, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон шаардлагатай мэргэжлийн ажилтантай хамтран ажиллана. Дэмжлэгийг суралцагчийг анги, хамт олноос тусгаарлалгүй нийтлэг үйл ажиллагаанд оролцуулахад чиглүүлнэ.

Нэгдүгээр ангийн суралцагчид тоон болон үсгэн үнэлгээ хэрэглэхгүй. Ажиглалтын тэмдэглэл нь товч, бодит үйлд тулгуурласан байх бөгөөд суралцагчийг шошголсон үг, дүгнэлт хэрэглэхгүй. Суралцагчийн эрүүл мэнд, хөгжлийн онцлог, гэр бүлийн нөхцөл, ажиглалт, үнэлгээний мэдээллийг зөвхөн тухайн суралцагчийг дэмжих зорилгоор ашиглаж, мэдээллийн нууцлалыг хангана.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Зорилго, хамрах хүрээ

Суралцагчийн эзэмшиж буй мэдлэг, чадварыг бодит болон тоглоомд суурилсан үйл ажиллагаагаар холбон хэрэглүүлэх, санаа гаргах, сонголт хийх, судлах, турших, бүтээх, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах, хийснээ эргэн харах үйлээр суурь болон ерөнхий чадамжийг хөгжүүлэхэд “Бүтээлч үйл ажиллагаа”-ны зорилго оршино.

“Бүтээлч үйл ажиллагаа”-г I ангийн бүх суралцагчид хичээлийн жилийн турш нийт 64 цагаар хэрэгжүүлнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 35 минут байх бөгөөд батлагдсан сургалтын төлөвлөгөөний улирлын цагийн хуваарилалтыг баримтална.

Үйл ажиллагааны үр дүн нь зөвхөн биет бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй. Санаа, асуулт, таамаг, шийдэл, дүрэм, загвар, зураглал, өгүүлэмж, тоглолт, хөдөлгөөн, хамтын шийдвэр болон сайжруулсан хувилбар байж болно.

“Бүтээлч үйл ажиллагаа”-г сургалтын агуулгыг давтах, хоцрогдол нөхөх, шалгалтад бэлтгэх, бүх суралцагчаар ижил загварын бүтээгдэхүүн хийлгэх, секц, дугуйлан, уралдаанаар орлуулах цаг болгон ашиглахгүй.

Хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт уг үйл ажиллагааг сургуульд дасан зохицох зорилготой уялдуулна.

2.2. Хүрэх үр дүн

Дараах үр дүнг суралцагч бүр ижил хугацаанд, ижил түвшинд заавал эзэмших шаардлага, дүн тавих болон эрэмбэлэх шалгуур болгон ашиглахгүй. Үр дүн нь суралцагчийн оролцоо, ахиц, дэмжлэгийн хэрэгцээг ажиглах, дараагийн үйл ажиллагааг төлөвлөх чиглэл байна.

Чиглэл	Хүрэх үр дүн
Санаа гаргах, сонголт хийх, төлөвлөх	Өмнөх туршлага, сонирхолдоо тулгуурлан асуулт асууж, санаа, гаргаж, илэрхийлэх хэлбэрээс сонголт хийнэ. Хийх үйлээ зураг, үг, бодит зүйлээр дараалуулна.
Асуух, судлах, мэдлэг чадвараа хэрэглэх	Бодит зүйл, үзэгдэл, зураг, зохиол, асуудалтай нөхцөлийг ажиглаж, асуулт асуух, ижил ба ялгаатай талыг таних, тоолох, ангилах, харьцуулах, энгийн таамаг гаргах үйлд оролцоно.
Бүтээх, турших, сайжруулах	Энгийн туршилт хийж, үр дүнг ажиглан бүтээл, шийдлээ өөрчлөх, засах, нэмэх, дахин оролдох үйлд оролцоно.
Харилцах, хамтран ажиллах	Өөрийн санааг үг, зураг, хөдөлгөөн, бүтээлээр илэрхийлж, бусдын санааг сонсох, үүрэг сонгох, хэрэглэгдэхүүн хуваалцах, тохиролцох, хамтын шийдвэрт хувь нэмэр оруулна.
Хийснээ эргэн харах, хариуцлагатай оролцох	Юу хийсэн, юу амжилттай болсон, юуг өөрчилж болохыг насанд тохирсон хэлбэрээр илэрхийлж, хэрэглэгдэхүүнээ зөв ашиглах, хураах, аюулгүй байдлын дэг мөрдөх, бусдын бүтээлийг хүндэтгэнэ.

Эдгээр үр дүн нь бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, суралцахууд суралцах, нийгэм-сэтгэл хөдлөл, үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах ерөнхий чадамжийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

2.3. Агуулгын чиглэл

“Бүтээлч үйл ажиллагаа”-ны агуулгыг сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, суурь болон ерөнхий чадамж, суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон асуудал, орон нутгийн болон сургуулийн орчин, нөөц боломжид тулгуурлан сонгоно.

Агуулгын чиглэл	Гол агуулга
Судлах, турших, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх	Ажиглах, асуух, таамаглах, тоолох, хэмжих, ангилах, харьцуулах, энгийн туршилт хийх, загвар бүтээх, ажиллагааг шалгах, алдааг засах.
Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх	Санаа, төсөөлөл, мэдрэмжээ яриа, зураг, урлал, зохиомж, хөгжим, хэмнэл, хөдөлгөөн, дүрийн тоглолтоор илэрхийлэх; эхний хувилбарыг өөрчлөх, шинээр зохиох.
Хамтран бүтээх, оролцох, орчноо дэмжих	Хамтын зорилго тодорхойлох, үүрэг сонгох, дүрэм тохирох, хэрэглэгдэхүүн хуваалцах, хамтын бүтээл, шийдэл гаргах; анги, сургууль, байгаль орчноо хамгаалах насанд тохирсон үйлд оролцох.
Өөрийгөө болон ажил хөдөлмөр, өв соёл, орон нутгаа танин мэдэх	Өөрийн сонирхол, чадварыг таних; гэр бүл, сургууль, орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийг мэдэх; үндэсний тоглоом, урлал, хөгжим, ахуй, байгаль, уламжлалаас суралцах.

Суралцагчийн санаачилга, сонголт, үйл ажиллагаагаа дараалуулах, эхэлснээ дуусгах, хийснээ эргэн харах үйл нь дээрх бүх агуулгын чиглэлд хөндлөн хэрэгжинэ.

Өөрийн гэсэн хөтөлбөр, арга зүй, хэрэглэгдэхүүн бүхий шатар, STEAM-д суурилсан үйл ажиллагааг хүрэх үр дүн, агуулгын чиглэлтэй уялдуулан сонгон хэрэглэж болно. Эдгээр нь заавал хэрэгжүүлэх бие даасан чиглэл, тогтмол цагийн хувь болохгүй.

2.4. Арга зүй, орчин, тохируулга

“Бүтээлч үйл ажиллагаа”-г дараах үндсэн үе шатаар зохион байгуулна.

Үе шат	Үндсэн үйл
Сонирхох, асуух	Бодит зүйл, зураг, зохиол, тоглоом, үзэгдэл, орчны асуудлыг ажиглаж, юу мэдэх, хийх, өөрчлөхөө тодруулна.
Санаа гаргах, сонгох, төлөвлөх	Санаа, таамаг, боломжит хувилбар гаргаж, үүрэг болон хийх дарааллаа сонгоно.
Судлах, турших, бүтээх	Бодит материалтай ажиллаж, тоглох, ажиглах, угсрах, зурах, хэмжих, харьцуулах, турших, шийдэл гаргах үйлд оролцоно.
Шалгах, өөрчлөх, сайжруулах	Хийсэн зүйл ажиллаж байгаа эсэх, анхны санаатай хэр нийцсэнийг ажиглаж, материал, хэлбэр, дараалал, дүрэм, санаагаа өөрчилж дахин туршина.
Хуваалцах, эргэцүүлэх	Хийсэн зүйл, хэрэглэсэн арга, амжилттай болсон болон өөрчилж болох зүйлийг үг, зураг, хөдөлгөөн, бүтээлээр хуваалцана.

Нэг ээлжит хичээлд дээрх бүх үе шатыг заавал бүрэн хэрэгжүүлэхгүй. Харин нэг сэдэв, бичил төслийн хүрээнд суралцагч санаа гаргах, хийх, шалгах, сайжруулах, хуваалцах боломжтой байна.

Үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн тоглоомд, зохиолд, шинжлэн судлахад, асуудал шийдвэрлэхэд, төсөлд суурилсан болон хамтран суралцах аргаас сонгон хэрэглэнэ. Багш бэлэн хариу, бэлэн бүтээгдэхүүн өгөхөөс өмнө суралцагчид бодох, сонгох, турших хугацаа олгож, шаардлагатай үед үлгэрлэн үзүүлэх, чиглүүлэх, нээлттэй асуулт ашиглах замаар дэмжинэ.

Орчин нь суралцагч ганцаар, хосоор, жижиг бүлгээр ажиллах, хөдөлгөөн хийх, материал сонгох, турших, бүтээлээ хадгалах, хийснээ хуваалцах боломжтой байна. Анги танхим, номын сан, урлаг, биеийн тамирын танхим, сургуулийн гадна талбай, орон нутгийн орчныг аюулгүй байдлын шаардлага хангасан нөхцөлд ашиглаж болно.

Хэрэглэгдэхүүн нь:

- нас, сэтгэхүйн онцлогт тохирсон;
- аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан;
- хүртээмжтэй, олон хувилбараар ашиглаж болох;
- орон нутгаас олдох боломжтой;
- гэр бүлд нэмэлт санхүүгийн дарамт үүсгэхгүй байна.

Гарын доорх, байгалийн, цэвэр, дахин ашиглах материал, эвлүүлдэг тоглоом, урлаг, хөдөлгөөн, хэмжилт, энгийн туршилтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно. Хэт халуун зүйл, химийн аюултай бодис, цахилгааны болон хурц аюултай хэрэгслийг I ангийн үйл ажиллагаанд ашиглахгүй.

Суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн заавар, хугацаа, орчин, хэрэглэгдэхүүн, хийх алхмын тоо, бүлгийн хэмжээ, хариу илэрхийлэх хэлбэрт тохируулга хийнэ. Тохируулгын дэлгэрэнгүй жишээг “Багшид зориулсан жишиг төлөвлөлт”-т тусгана.

2.5. Хэрэгжилт, зохион байгуулалт

Сургалтын менежер, I ангийн багш нар “Бүтээлч үйл ажиллагаа”-ны жилийн төлөвлөлтийг хамтран боловсруулна. Төлөвлөлтөд тухайн улирлын цаг, сэдэв, гол асуулт, асуудал, холбогдох суралцахуйн үр дүн, дэмжих чадамж, суралцагчийн хийх гол үйл, орчин, хэрэглэгдэхүүн, аюулгүй байдал, тохируулга, явцын үнэлгээг тусгана.

Жилийн төлөвлөлтийг нэг төрлийн үйл ажиллагаа, тоглоом, хэрэглэгдэхүүнээр бүхэлд нь зохион байгуулахгүй. Судлах, турших, зохион бүтээх, урлаг, хөдөлгөөн, тоглоом, хамтран бүтээх, өв соёл, байгаль, орон нутгийн агуулгыг тэнцвэртэй хангана.

Үйл ажиллагааг:

- 35 минутын нэг ээлжит хичээл;
- завсарлагатай дараалсан хоёр ээлжит хичээл;
- хэд хэдэн ээлжит хичээлээр үргэлжлэх бичил төсөл хэлбэрээр зохион байгуулж болно.

Ээлжит хичээлийг сонирхол өдөөх, санаа гаргах, судлах–турших–бүтээх, хуваалцах–эргэцүүлэх үндсэн дарааллаар суралцагчийн нас, анхаарал, оролцоонд нийцүүлэн уян хатан зохион байгуулна. Нарийвчилсан хугацааны жишгийг багшид зориулсан жишиг төлөвлөлтөд тусгана.

Хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт ангийн таних тэмдэг, сургуулийн маршрут, хэрэглэгдэхүүний байрлал, ангийн зурагт дүрэм, найзтайгаа хамтран бүтээх, мэдрэмжээ дүрслэх, аюулгүй орчныг ялгах зэрэг дасан зохицох зорилготой үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлж болно.

Сургууль, багш, сэдэв, дараалал, хэрэглэгдэхүүнийг өөрчилж болох боловч батлагдсан цаг, зорилго, нийтлэг зарчим, суралцагчийн тэгш оролцоо, аюулгүй байдлыг хангана.

2.6. Явцын үнэлгээ, баримтжуулалт

“Бүтээлч үйл ажиллагаа”-ны үнэлгээ нь суралцагчийн оролцоо, санаа, сонголт, мэдлэг, чадвараа хэрэглэж буй байдал, судлах, турших, хамтран ажиллах, дахин оролдож сайжруулах ахицын талаар мэдээлэл цуглуулж, дараагийн үйл ажиллагаа, багшийн дэмжлэг, орчин, хэрэглэгдэхүүн, тохируулгыг сайжруулахад чиглэнэ.

Үнэлгээнд дараах үндсэн баримтаас зорилгод тохирохыг сонгон ашиглана:

- өдөр тутмын ажиглалт;
- суралцагчийн асуулт, санаа, тайлбар;
- бүтээл, загвар, эхний болон сайжруулсан хувилбар;
- хос, бүлгийн үйл ажиллагаан дахь оролцоо;
- суралцагчийн насанд тохирсон өөрийн үнэлгээ.

Нэг ээлжит хичээлээр бүх үр дүнг ажиглахгүй. Тухайн үйл ажиллагааны зорилготой холбоотой нэгээс гурван чиглэлийг сонгож, өөр өөр хугацаа, орчин, үйл ажиллагаанд цугларсан баримтыг хамтатган авч үзнэ.

Суралцагчид өгөх эргэх холбоо нь товч, ойлгомжтой, хийсэн үйл, оролдлого, ахицад тулгуурласан, дараагийн алхмыг чиглүүлсэн байна. Ямар санаа гаргасан, ямар арга туршсан, хэрхэн хамтарсан, юуг өөрчилсөн талаар тодорхой мэдээлнэ.

Бүтээлийн хавтсыг бүх ажлыг хадгалах цуглуулга бус суралцагчийн үйл явц, ахиц, сайжруулалтыг харуулах сонгосон баримтын бүрдэл болгон ашиглаж болно. Бүтээлийн хавтас, өөрийн үнэлгээ, багшийн тэмдэглэл, эргэх холбооны загварыг “Багшид зориулсан жишиг төлөвлөлт”-д тусгана.

Суралцагчийн бүтээл, зураг, аудио, дүрс бичлэг, ажиглалт, үнэлгээний мэдээллийг хадгалах, ашиглах, нийтлэхдээ холбогдох зөвшөөрөл болон мэдээллийн нууцлалын шаардлагыг баримтална.

Харин жишиг үйл ажиллагаа, төлөвлөлт, хугацаа, хэрэглэгдэхүүн, оролцооны хэлбэрийг суралцагчийн хэрэгцээ, сургуулийн онцлог, анги дүүргэлт, хүний нөөц, орчин, хэрэглэгдэхүүний боломж, орон нутгийн хэл, соёлын онцлогт тохируулан хэрэгжүүлж болно.